



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

“ХАРААГҮЙ ХҮМҮҮСИЙН ХӨДӨЛМӨР
СУРГАЛТЫН ҮЙЛДВЭР” ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ З.БОЛДСАЙХАН ТАНАА

2017.02.23 № 3/291
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлант Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Handwritten signature

Ц.НАРАНЧИМЭГ

УХА0122



ХАРААГҮЙ ХҮМҮҮСИЙН ХӨДӨЛМӨР СУРГАЛТЫН ҮЙЛДВЭР ТӨААТУГ-ЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

ТАБ-ын Санхүүгийн аудитын
газрын дарга, Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 261885
Цахим хаяг:
sambuunyamya@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Батсайхан
Утас: 260512
Цахим хаяг:
Batsaikhann@audit.gov.mn

ТАБ-ын хаяг:
Үндэсний аудитын газар
Байршил: Засгийн газрын IY байр,
Бага тойруу 6, Улаанбаатар-46
Цахим хуудас: www.audit.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
“Баян Сагсай Аудит” ХХК
Утас: 99090188
Цахим хуудас: www.bsaudit.mn
Цахим хаяг:
munkhtsetseg@bsaudit.mn

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ/2017/174/СТА -ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн Сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 11 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-тай 48 дугаар гэрээ байгуулсаны үндсэн дээр “ Баян Сагсай Аудит “ ХХК –ийн аудиторууд хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланг 2016 оны 1 дүгээр сарын 25-нд 005/2017 дугаар бүхий албан тоотын хамт Баян Сагсай Аудит ХХК-д ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2016 оны 11 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 25-нд Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” болон бусад холбогдох хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх, хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын захирал Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын төсвийн 2016 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 33-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан захирлын 34 дугаар тушаалаар батлуулан 2010 оны 3 дугаар сарын 9-нээс эхлэн мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС-тай нийцсэн байна. Бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт дунд байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Хүн ам хөгжил нийгмийн хамгаалалын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын үндсэн үйл ажиллагааны нийт орлого 465.1 сая төгрөг, үүнээс төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс тогтмол зардалд 290.7 сая төгрөгийн санхүүжилт авч, бараа үйлчилгээний борлуулалтаас 198.3 сая төгрөгийн орлого, 24.0 сая төгрөгийн бусад орлого орсон байна. Нийт зардал 601.4 сая төгрөг, үүнээс тогтмол зардалд 291.6 сая төгрөг батлагдсанаас 290.7 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 0.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсан ба 112.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж shilendans.gov.mn веб сайт дээр цалин хөлснөөс бусад 5.0 сая төгрөгнөөс дээш төрийн сангаас хийгдсэн бүх гүйлгээг байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 16 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 16 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, бараа материал, үндсэн хөрөнгө, борлуулалтын орлого, цалин хөлсний тооцоо, засвар үйлчилгээ, шуудан холбооны зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна.

Үүнд:

1. Бэлэн мөнгөний кассаас хувь хүнээс худалдан авалт хийж 2.0 сая төгрөгийн орлого олгосноос ХХОАТ суутган тооцоогүй байгаа нь ХХОАТ-ын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-12.3-д “үйл ажиллагааны орлого”-оос 10 хувиар албан татвар ноогдуулан төлнө гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар хувь хүнээс бараа материал худалдан авсан үед ХХОАТ-ын хуулийн дагуу албан татвар ноогдуулан суутгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэн, төлсөн татварыг албан татвар төлөгчийн орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тухай бүр бүртгэж байх талаар зөвлөмж хүргүүлэв.

2. Баримтын бүрдэл дутуу 1.0 сая төгрөгийн бараа материал үнэ бүхий зүйл худалдан авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7-д заасан “анхан шатны баримт бүрдүүлээгүй, заавал хөтлөх ёстой журнал, ерөнхий дэвтэр, дэлгэрэнгүй бүртгэлийн дэвтрийг хөтлөөгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийхгүй байх, анхан шатны баримтын дагуу ажил гүйлгээг бүртгэж байх талаар зөвлөмж хүргүүлэв.

3. Түрээсийн орлого болох 10.2 сая төгрөгийн 20 хувь буюу 2.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна...” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай гэрээ байгуулж, түрээсийн орлогын 20 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх талаар зөвлөмж хүргүүлэв.

4. 79.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэйгээс 42.4 сая төгрөгийн авлагад тооцоо нийлээгүй байна. Тооцоо нийлээгүй авлагын үлдэгдэлд Хаврын Солонго Эко Нийгэмлэг ТББ-аас авах 31.4 сая төгрөгийн авлага байна. Мөн 189.0 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаагаас НДШ-ийн өглөг 82.0 сая төгрөг байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар авлага болон өглөгийг шуурхай барагдуулах арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Залруулагдаагүй алдаа байхгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

2014 онд үүссэн Хаврын Солонго Эко Нийгэмлэг ТББ-аас авах 31.4 сая төгрөгийн авлагын эзэн холбогдогч нь олдохгүй байгаа шалтгаанаар мөрдөн байцаалтын шатанд түдгэлзсэн байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 47.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 47.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, төлбөрийг барагдуулах акт тогтоогдоогүй. 47.8 сая төгрөгийн зөрчлийн 31.4 сая төгрөг нь 2014 онд үүссэн Хаврын Солонго Эко Нийгэмлэг ТББ-аас авах ёстой, хууль хяналтын байгууллагын шатанд явж байгаа авлагын дүн юм.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэр ТӨААТҮГ-ын 2015 оны санхүүгийн тайланд Баян Сагсай Аудит ХХК-аас хийсэн аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжүүдийг хагас хэрэгжүүлсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн Сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 9 хуудас, ХХХСҮ ТӨААТҮГ-ийн 2016 оны жилийн тайлан, тодруулга, судалгаа 22 хуудас тус тус хавсаргав.



ХАРААГҮЙ ХҮМҮҮСИЙН ХӨДӨЛМӨР СУРГАЛТЫН ҮЙЛДВЭР ТӨААТҮГ-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Мөнгөн хөрөнгийн талаар.....11

Асуудал 2

Түрээсийн орлогын талаар.....12

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1

Мөнгөн хөрөнгийн талаар.....13

Асуудал 2

Авлага, өр төлбөрийг шуурхай

барагдуулах.....14

2017 оны 2 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Мөнгөн хөрөнгө	Тэргүүлэх ач холбогдол №1
----------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Бэлэн мөнгөний кассаас хувь хүнээс худалдан авалт хийж 2.0 сая төгрөгийн орлого олгосноос ХХОАТ суутган тооцоогүй байгаа нь ХХОАТ-ын тухай хуулийн 12 дугаар зүйлд “ үйл ажиллагааны орлого”-оос 10 хувиар албан татвар ноогдуулан төлнө гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Хувь хүмүүст олгосон орлогоос 10 хувиар тооцож, ХХОАТ-ын нөхөн татвар нэмээд алданги, торгуулийн эрсдэл хүлээхээр байна.

ҮАГ-ын зөвлөмж

ХХОАТ-ын хуулийн дагуу албан татвар ноогдуулан суутгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Түрээсийн орлого	Тэргүүлэх ач холбогдол №1
------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Түрээсийн орлого болох 10.2 сая төгрөгийн 20 хувь буюу 2.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй нь “ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д заасан “ Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна...” гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай гэрээ байгуулж, түрээсийн орлогын 20 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх талаар зөвлөмж өгөх.

Эрсдэлүүд

Холбогдох хуулийн заалтыг зөрчсөн.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 1: Мөнгөн хөрөнгө	Тэргүүлэх ач холбогдол №2
----------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Баримтын бүрдэл дутуу 1.0 сая төгрөгийн бараа материал үнэ бүхий зүйл худалдан авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 –р зүйлийн 20.1.7-д заасан “анхан шатны баримт бүрдүүлээгүй, заавал хөтлөх ёстой журнал, ерөнхий дэвтэр, дэлгэрэнгүй бүртгэлийн дэвтрийг хөтлөөгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийхгүй байх, анхан шатны баримтын дагуу ажил гүйлгээг бүртгэж байх талаар зөвлөмж хүргүүлэв.

Эрсдэлүүд

Зарлагын гүйцэтгэл буруу илэрхийдэгдэх, төсвийг зориулалт бусаар зарцуулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Авлага, өглөг	Тэргүүлэх ач холбогдол №2
---------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

79.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэйгээс 42.4 сая төгрөгийн авлагад тооцоо нийлээгүй байна. Тооцоо нийлээгүй авлагын үлдэгдэлд Хаврын Солонго Эко Нийгэмлэгээс авах 31.4 сая төгрөгийн авлага байна. Мөн 189.0 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаагаас НДШ-ийн өглөг 82.0 сая төгрөг байна.

ҮАГ-ын зөвлөмж

Авлага, өглөг барагдуулах ажлыг шуурхай зохион байгуулах

Эрсдэлүүд

Ажлын капиталын хэмжээ буурч, эргэлтийн хөрөнгө болон түүхий эд материалын дутагдалд орж байгууллагын хэвийн үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

2016 оны 12 сарын 31-ээрх

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2015 он	2016 он
	төгрөг	төгрөг
1. ХӨРӨНГӨ		
1.1 Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,512,638.11	1,055,156.13
Дансны авлага	61,305,800.00	79,437,933.00
Бараа материал	199,596,391.93	137,602,004.47
Эргэлтийн хөрөнгийн дүн	263,414,830.04	218,095,093.60
1.2 Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	959,563,561.23	940,697,464.65
Биет бус хөрөнгө	158,466.67	81,466.67
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	959,722,027.90	940,778,931.32
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,223,136,857.94	1,158,874,024.92
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1 Өр төлбөр		
Дансны өр	11,644,800.00	38,876,400.00
Цалингийн өр	9,210,298.00	28,798,118.20
Татварын өр	2,680,612.00	11,427,439.00
НДШ-ийн өр	52,049,294.63	81,957,668.07
Богино хугацаат зээл	65,406,250.09	28,031,250.13
Богино хугацаат өр төлбөрийн дүн	140,991,254.72	189,090,875.40
Урт хугацаат зээл		
Бусад урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөрийн дүн		
Нийт өр төлбөрийн дүн	140,991,254.72	189,090,875.40
2.2 Эзэмшигчдийн өмч		
Төрийн өмч	735,641,614.84	735,641,614.84
Дахин үнэлгээний нэмэгдэл	464,585,299.00	464,585,299.00
Хуримтлагдсан ашиг, алдагдал	(118,081,310.62)	(230,443,764.31)
Эзэмшигчдийн өмчийн дүн	1,082,145,603.22	969,783,149.53
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,223,136,857.94	1,158,874,024.93

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2016 оны 12 сарын 31

ҮЗҮҮЛЭЛТ	2015 он	2016 он
	төгрөг	төгрөг
Борлуулалтын цэвэр орлого	608,106,626.00	454,584,208.00
Борлуулалтын өртөг	102,812,342.68	118,830,487.66
Нийт ашиг, алдагдал	505,294,283.32	335,753,720.34
Түрээсийн орлого		10,279,760.00
Хүүний орлого	6,443.12	
Бусад орлого	25,986,082.00	24,169,234.62
Ерөнхий удирдлагын зардал	546,399,598.65	462,580,508.51
Санхүүгийн зардал	8,774,113.19	6,819,080.14
Бусад зардал	19,854,129.00	13,165,580.00
Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	(43,741,032.40)	(112,362,453.69)
Орлогын албан татварын зардал		(112,362,453.69)
Татварын дараах ашиг, алдагдал	(43,741,032.40)	(112,362,453.69)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг, алдагдал		
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	(43,741,032.40)	(112,362,453.69)

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2016 оны 12 сарын 31

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2016 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл				
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Залруулсан үлдэгдэл				
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчид гаргасан өөрчлөлт				
Зарласан ногдол ашиг				
Дахин үнэлгээний нэмэгдэл				
2016 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл				
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	735,641,614.84	464,585,299.00	(118,081,310.62)	1,082,145,603.22
Залруулсан үлдэгдэл				
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(112,362,453.69)	(112,362,453.69)
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчид гаргасан өөрчлөлт				-
Зарласан ногдол ашиг				
Дахин үнэлгээний нэмэгдэл				
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	735,641,614.84	464,585,299.00	(230,443,764.31)	969,783,149.53

Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалтын Үйлдвэр ТӨААТҮГ-ын аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

2016 оны 12 сарын 31

	2015 он төгрөг	2016 он төгрөг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	679,564,181.00	464,232,393.62
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	195,351,340.00	132,191,750.00
Даатгалын нөхөн олговор	2,289,473.00	4,993,430.00
Татаас санхүүжилтын орлого	305,872,486.00	290,662,619.00
Бусад мөнгөн орлого	176,050,882.00	36,384,594.62
Мөнгөн зарлагын дүн	590,562,287.11	444,802,875.64
Ажиллагсад төлсөн	250,361,795.00	229,185,000.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	21,396,200.00	21,096,500.00
Бараа материал худалдан авахад төлсөн	139,765,296.10	60,245,052.50
Ашиглалтын зардалд төлсөн	65,932,486.00	76,831,914.00
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэл төлсөн	6,622,760.00	8,876,439.00
Хүүний төлбөрт төлсөн	9,067,746.23	6,684,480.14
Татварын байгууллагад төлсөн	9,360,913.00	289,800.00
Даатгалын төлбөрт төлсөн	145,490.00	511,770.00
Бусад мөнгөн зарлага	87,909,600.78	41,081,920.00
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	89,001,893.89	19,429,517.98
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	1,506,443.12	23,500,000.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		23,500,000.00
Бусдад олгосон зээл мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,500,000.00	
Хүлээн авсан хүүгийн орлого	6,443.12	
Мөнгөн зарлагын дүн	1,500,000.00	44,386,999.96
Зээл, өрийн үнэт цаас төлбөрт төлсөн мөнгө		44,386,999.96
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,500,000.00	
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	6,443.12	
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	24,078,295.00	
Зээл авсан, үнэт цаас худалдсан	24,078,295.00	
Мөнгөн зарлагын дүн	111,031,811.92	
Зээл, үнэт цаасны төлбөр	111,031,811.92	
Бусад		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(86,953,516.92)	(20,886,999.96)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,054,820.09	(1,457,481.98)
Мөнгөний эхний үлдэгдэл	457,818.02	2,512,638.11
Мөнгөний эцсийн үлдэгдэл	2,512,638.11	1,055,156.13

ХАРААГҮЙ ХҮМҮҮСИЙН ХӨДӨЛМӨР СУРГАЛТЫН ҮЙЛДВЭР ТӨААТУГ-ЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө төгрөг	Гүйцэтгэл төгрөг	Өөрчлөлт Зөрүү	Хувь
1. ОРЛОГО				
<i>Татаас санхүүжилын орлого</i>	291,601,600.00	290,067,600.00	1,534,000.00	
Улсын төсвөөс	291,601,600.00	290,067,600.00	1,534,000.00	99%
Бусад		601,019.00	601,019.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	291,601,600.00	290,668,619.00	932,981.00	100%
2. ЗАРДАЛ				
<i>Ажиллагсадтай холбогдсон зардал</i>				
Цалин	142,424,200.00	163,412,100.00	(20,987,900.00)	115%
Цалингийн тусгай нэмэгдэлүүд /унаа, хоолны хөнгөлөлт/	20,988,000.00		20,988,000.00	0%
Гэрээт ажлын цалин	28,371,700.00	28,371,700.00	-	100%
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	17,975,500.00	17,975,500.00	-	100%
Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,121,000.00	3,121,000.00	-	100%
Дүн	212,880,400.00	212,880,300.00	100.00	
<i>Бараа үйлчилгээний урсгал зардал</i>				
Гэрэл, цахилгаан	18,337,700.00	41,061,324.00	(22,723,624.00)	224%
Түлш, халаалтын зардал	40,729,900.00	20,304,702.00	20,425,198.00	50%
Цэвэр, бохир усны зардал	8,445,800.00	6,147,374.00	2,298,426.00	73%
Тээвэр, шатахууны зардал	4,926,500.00	4,926,500.00	-	100%
Шуудан холбооны зардал	1,430,900.00	1,430,900.00	-	100%
Маягт хэвлүүлэх зардал /даатгал/	550,200.00	511,770.00	38,430.00	93%
Урсгал засварын зардал	1,600,000.00	1,600,000.00	-	100%
Холбооны суваг ашигласны зардал (бусад)		595,018.00	(595,018.00)	
Хөтөлбөр арга хэмжээний зардал(төсөвт)		44,531.00	(44,531.00)	
Гадаад зочны зардал	289,800.00	289,800.00	-	100%
Ажил олгогчоос олгох, тэтгэмж, урамшуулал	2,410,400.00	876,400.00	1,534,000.00	36%
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал				
Дүн	78,721,200.00	77,788,319.00	932,881.00	99%
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	291,601,600.00	290,668,619.00	932,981.00	

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТОДРУУЛГА

Санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө болон түүний эх үүсвэрийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

а) Мөнгөн хөрөнгө

Тус байгууллага нь Төрийн сан, Улаанбаатар, Хас, Хаан, Төрийн банкуудад тус тус харилцах данстай. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2015 он төгрөг	2016 он төгрөг
Кассанд байгаа бэлэн мөнгө	724,933.48	20,307.50
УБ банк төгрөг	268,394.51	236,394.51
Хас банк төгрөг	9,940.15	139,000.00
Хаан банк төгрөг	94,950.00	19,250.00
Төрийн банк төгрөг	9,930.00	640,204.12
Нийт дүн	1,108,148.14	1,055,156.13

б) Дансны авлага

Хаврын Солонго Эко Нийгэмлэг ТББ-аас авах 31 400 000 төгрөгийн дансны авлага нь авлагын нийт үлдэгдлийн 51.2 хувийг эзэлж байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2015 он төгрөг	2016 он төгрөг
Дансны авлага	61,305,800.00	79,437,933.00
Нийт дүн	61,305,800.00	79,437,933.00

в) Бараа материал

Байгууллага үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор бэлтгэсэн түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа болон хангамжийн материал зэргийг бараа материал дансанд бүртгэсэн.

ҮЗҮҮЛЭЛТ	2015 он төгрөг	2016 он төгрөг	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Түүхий эд материал	16,948,024.37	12,371,724.37	(4,576,300.00)	73%
Дуусаагүй үйлдвэрлэл	54,373,585.30	51,764,623.10	(2,608,962.20)	95%
Бэлэн бүтээгдэхүүн	30,267,697.66	32,779,507.00	2,511,809.34	108%
Бараа	4,003,874.00	3,587,990.00	(415,884.00)	90%
Хангамжийн материал	94,003,210.60	37,098,160.00	(56,905,050.60)	39%
Нийт дүн	199,596,391.93	137,602,004.47	(61,994,387.46)	406%

г) Үндсэн хөрөнгө

Байгууллага нь барилга байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил болон нийтийн эзэмшлийн хөрөнгө гэсэн үндсэн хөрөнгүүдтэй.

ҮЗҮҮЛЭЛТ	2015 он	Өөрчлөлт		2016 он
	төгрөг	Нэмэгдсэн	Хасагдсан	төгрөг
Барилга байгууламж	1,873,085,212.00			1,873,085,212.00
Тоног төхөөрөмж	237,223,173.84	38,226,500.00		275,449,673.84
Тээврийн хэрэгсэл	31,830,000.00			31,830,000.00
Тавилга эд хогшил	21,978,687.00	1,400,000.00		23,378,687.00
Бусад хөрөнгө	2,331,000.00			2,331,000.00
Нийт дүн	2,166,448,072.84			2,206,074,572.84

д) Үндсэн хөрөнгийн элэгдэл

Үндсэн хөрөнгийн элэгдлийг ашиглах хугацааг үндэслэн шулуун шугамын аргаар байгуулсан байна. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэл дараах байдалтай байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2015 он	Өөрчлөлт		2016 он
	төгрөг	Нэмэгдсэн	Хасагдсан	төгрөг
Барилга байгууламж	1,029,820,307.06	29,056,753.53		1,058,877,060.59
Тоног төхөөрөмж	127,074,673.64	27,720,375.53		154,795,049.17
Тээврийн хэрэгсэл	31,479,993.33	350,006.67		31,830,000.00
Тавилга эд хогшил	16,178,537.58	1,365,460.85		17,543,998.43
Бусад хөрөнгө	2,331,000.00			2,331,000.00
Нийт дүн	1,206,884,511.61	58,492,596.58		1,265,377,108.19

е) Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгөд программ хангамжыг бүртгэсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2015 он	Өөрчлөлт		2016 он
	төгрөг	Нэмэгдсэн	Хасагдсан	төгрөг
Программ хангамж	770,000.00			770,000.00
Нийт дүн	770,000.00	-		770,000.00

ё) Биет бус хөрөнгийн элэгдэл

Программ хангамжинд шулуун шугамын аргаар элэгдэл байгуулсан байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2015 он	Өөрчлөлт		2016 он
	төгрөг	Нэмэгдсэн	Хасагдсан	төгрөг
Программ хангамж	611,533.00	77,000.00		688,533.00
Нийт дүн	611,533.00	77,000.00		688,533.00

ж) Богино хугацаат өр төлбөр

Нийт өр төлбөрийн 46.4 хувийг НДШ, 20.5 хувийг дансны өглөг, 15.2 хувийг цалингийн өглөг, 14.8 хувийг богино хугацаат зээл, 3.1 хувийн татварын өр эзэлж байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2015 он төгрөг	2016 он төгрөг
<i>Дансны өглөг</i>		
Дансны өглөг	11,644,800.00	38,876,400.00
Дүн	11,644,800.00	38,876,400.00
<i>Цалингийн өр</i>		
Цалингийн өр	9,210,298.00	28,798,118.20
Дүн	9,210,298.00	28,798,118.20
<i>Татвар, шимтгэлийн болон бусад өглөг</i>		
ХХОАТ-ын өр	2,680,612.00	11,427,439.00
Дүн	2,680,612.00	11,427,439.00
<i>НДШ-ийн өглөг</i>		
НДШ-ийн өглөг	52,049,294.63	81,957,668.07
Дүн	52,049,294.63	81,957,668.07
<i>Бусад өглөг</i>		
Богино хугацаат зээл	65,406,250.09	28,031,250.13
Дүн	65,406,250.09	28,031,250.13
Нийт дүн	140,991,254.72	189,090,875.40

з) **Эзэмшигчийн өмч**
байна.

Эзэмшигчийн өмчийн үлдэгдэл дараах байдалтай

ҮЗҮҮЛЭЛТ	2015 он төгрөг	2016 он төгрөг
Төрийн өмч	735,641,614.84	735,641,614.84
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	464,585,299.00	464,585,299.00
Хуримтлагдсан ашиг	(118,081,310.62)	(230,443,764.31)
Нийт дүн	1,082,145,603.22	969,783,149.53

и) **Байгууллагын орлого,
зардал**

Тус байгууллагын үйл ажиллагааны орлого, зардал 2015 онд дараах байдалтай байна.